

1993 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД ХИЙСЭН  
ДҮН ШИНЖИЛГЭЭ

Н.Урантогтох\*

\* МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

**Түлхүүр үгс:** улс төрийн PR, улстөрч ба сонгогч, сэтгүүл зүй, имиж ба Ерөнхийлөгчийн сонгууль

**М**онгол Улс бол “дэлхий дээрх хоёр дахь коммунист улс байсан бөгөөд 1990 оноос хойш харьцангуй богино хугацаанд Зөвлөлтийн дагавраас ардчилсан улс болох шилжилтээ хийж, Зүүн Европыг эс тооцвол коммунист дэглэмээс ардчилалд амжилттай шилжсэн цорын ганц улс” (Аренд Лийпхарт, 2007.) хэмээн судлаач Арэнд Лийпхарт онцолжээ. Ардчилалд шилжихдээ Монголын ард түмэн парламентын засаглалтай, бүх ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч төрийн тэргүүн Ерөнхийлөгчтэй байх сонголт хийв. 1992 оны ардчилсан Үндсэн хууль нь Монгол Улсад хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын эрх мэдлийг зохистой хуваарилахын зэрэгцээ харилцан хяналтад түшиглэсэн засаглалын тэнцвэртэй, хариуцлагатай тогтолцоог бий болгох замаар төрийн эрх мэдэл нэг гарт төвлөрөхөөс сэргийлж, засаглалын институтууд бие даан шийдвэр гаргахын зэрэгцээ хамтран ажиллах харил-

цааг тодорхойлж өгсөн юм. Парламентын засаглалтай Монгол Улс нь Ерөнхийлөгчийн институцийг төрийн байгуулалдаа багтааснаар холимог хэлбэрийн төрийн тогтолцоог сонгон хөгжүүлж байна (Я.Төгөлдөр, Д.Бумдарь, 2021).

Ерөнхийлөгч бол улс орны хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн улс төрийн хошуучлагчийн хийдэг ажил, бие даасан институт хэмээн ойлгож болно. Иймээс улс төрийн хошуучлагч, түүний имижийн асуудлыг сэтгүүл зүйн үүднээс судлан үзэхээр оролдлоо. Улс төрийн лидер, түүний имиж нь олон нийтийн дэмжлэг авч хүлээн зөвшөөрөгдөх, үгүйсгэгддэг нь 1993 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар тод харагдав.

1993 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас эрдэмтэн, зохиолч Л.Түдэв нэр дэвшсэн нь тухайн цаг үе, олон нийтийн хүсэн хүлээсэн улс төрч биш байлаа. Коммунизмын дараах шилжилтийн үеийн айдас, эдийн засгийн гүн хямрал, мөнгөний уналт (20-р тогтоол) болоод ардчилал, чөлөөт зах зээл, хувийн өмч дээдэлсэн нийгэм, олон нийтийн догдлол дунд

эрдэм ном, утга зохиолын "лидер"-ийг дэмжих орон зай үгүй байв. Түүний сонгуулийн сурталчилгаа "оюуны өндөр чадвартай", "мэдлэг боловсролын ноён оргил", "нэрт соён гэгээрүүлэгч" гэсэн үнэлэлт, тайлбарт нэгтгэгдэж байв. Хамгийн хачирхалтай нь нэр дэвшигч Л.Түдэвд Ерөнхийлөгчид нэр дэвших, сонгогдох хүсэл бага байсан төдийгүй идэвх оролцоо ч сул байжээ. Тэрээр МАХН-ын бүгд хурал дээр нэр дэвшигчийн жагсаалтаас сайн дураараа татгалзаж, Монголын үндэсний телевизээс зохион байгуулсан халз мэтгэлцээний үеэр Ерөнхийлөгч болох зорилго хүсэлгүйгээ ил тод илэрхийлж, тэр ч бүү хэл уг нэвтрүүлгийн үнэ цэнэ, ач холбогдлыг эрс үгүйсгэж байв. Тэрээр социализмын үеийн улс төрийн соёл, лидерийн хэв шинжийг агуулж байлаа. Гэтэл ардчилсан тогтолцоо, нээлттэй нийгмийн онцлог нь тэс өөр байсан юм.

"П.Очирбат ард түмэнд тохируулж, тэдэнд таалагдах үгийг л сонгож хэлж байсан бол Л.Түдэв ард түмнээсээ түрүүлсэн, хэтийдсэн зүйлсийг ярьж байв. Тухайлбал, тухайн үед нар салхи, усны хүчийг ашиглах тухай ярьсан нь тэр цагт үлгэр шиг л сонсогдож байлаа. Мөн өрх бүр үйлдвэр, хүн бүр үйлдвэрлэгч гэх мэт хачин жигтэй үгүүд хэлж, "Би сонгогдвол импортыг хязгаарлаж, Монголчууд бүсээ чангална. Ингэж л бид өөрсдөө үйлдвэрлэгч болно" гэж ярьсан нь олон нийтэд үнэхээрийн таалагдахгүй байлаа. Тэр үед ард түмэн бүсээ чангалах тухай сонсохыг ч хүсэ-

хээргүй байсныг Л.Түдэв ойлгоогүй юм. Харин эсрэг талд П.Очирбат ард түмэн юу хүсч байгааг маш сайн мэдэж байв. Дутагдаж гачигдахын дээс хоолойд нь тулж ирсэн ард түмэнд тэр алт, эд баялаг, элбэг дэлбэгийг амласан юм. П.Очирбатын сонгуулийн гол илгээлт нь "Гарам дээр морио сольдоггүй" гэсэн үг байсан юм ...Халз мэтгэлцээний өмнөх судалгаа, тандалтаар Л.Түдэв 60 гаруй хувиар илүү явж байсан бол мэтгэлцээний дараа сонгогчдын санаа бодол эргэсэн байжээ" (Д.Дамдинжав, 2018).

**С**оциалист тогтолцооны үед улс төрийн манлайлал, албан тушаал өгсөх "шат" нь хамтын удирдлага, нэгдмэл зохион байгуулалтын зарчимд тулгуурлаж байв. Ийм цаг үед хувь улс төрчийн онцлог, бие даасан байдал, олон нийт хүлээн зөвшөөрсөн хандлага, иргэдийн сонголт чухал биш гагцхүү дээд түвшний зөвшилцөл бүхнийг зохицуулж байлаа.

Бүх нийтийн нээлттэй, ардчилсан, чөлөөт сонгууль нь Монголын ард түмэн, нийгмийн бүлгүүдийн хувьд цоо шинэ зүйл байв. Өмнө нь ганцхан нэр дэвшигчийн төлөө албан үүргээр санал өгдөг байсан бол улс орныхоо төрийн тэргүүнийг бүх нийтээр хараат бус сонгох боломж бүрдэв. Энэ бол улс төрийн ууган хүчинд ч, шинэ цаг үеийн ардчилсан намуудад ч шинэ сорилт, туулж үзээгүй зам байлаа. Тухайн цаг үеийн ердийн ойлголтоор бол МАХН-аас нэр дэвшинэ гэдэг нь бараг л ялалт байв. Гэвч Л.Түдэв нийт сонгогчдын 38.7 хувийн санал

авч ялагдсан. Үүний шалтгаан нь сонгуулийн сурталчилгааны арга барил, хэвлэл мэдээллийн оновчтой бодлого, зөв зохион байгуулалт бүхий компани ажил дутагдсанд оршино. МАХН-аас нэр дэвшигч Л.Түдэв нь “Монголоо Монголын ард түмэн аварна” гэсэн хэт гүн ухааны, ерөнхий, тухайн цаг үеийн нийгэм олон нийтэд төдий л нөлөөлөхгүй үг ойлголт бүхий уриа дэвшүүлж байв. Түүний мөрийн хөтөлбөр, бодлого, байр суурь “эрх бүр үйлдвэрлэгч, хүн бүр үйлдвэрлэгч” байх тухай хөндсөн. Харин тухайн цаг үед ганзагын наймаа ид цэцэглэн, иргэд богино хугацаанд их мөнгө ашиг олох нь чухал байв. Мөн зах зээлийн нийгэм буюу чөлөөт эдийн засагт орсноор “бүх зүйл сайхан болно” гэсэн өөдрөг тэмүүллийн туйлшрал явагдсан. Ийм үед “үйлдвэрлэгч”, “Монголоо аврах” номлолын санаачилга нь хэт эртэдсэн зүйл байлаа. Улс төрийн үзэл санаа гэдэг зүйл олон нийтийн санаа бодолд бүрэн нийцэх ёстой нь үүнээс харагдсан.

**А**рдчилсан тогтолцооны мөн чанар нь улс төрийн эрх мэдлийг сонгуулиар, олонхын санал оролцоогоор шийддэг, төрийн удирдлага нэг улс төрийн хүчнээс нөгөөд шилждэг дэг журам, хэм хэмжээ, зарчимд оршдог. Харин улс төрийн лидерийн имиж нь сонгогч, олон нийтийн хүлээн зөвшөөрсөн хувь хүний онцлог, мөн чанарт тулгуурлан давуу тал бий болгодог. Тухайн цаг үед олон нийтийн санаа бодол юунд чиглэж байна, нийгмийн сэтгэл зүй ямар эрэлт хэрэгцээг хүсэж буйг мэдэрч байж л түүнд

нийцсэн улс төрийн үзэл санаа, үг үйлдэл, шийдвэр манлайлал гаргах ёстой. Гэтэл МАХН-аас нэр дэвшигч нь зохиолч, соён гэгээрүүлэгч гэсэн давуу талаа мэдээлэл сурталчилгаандаа түлхүү ашиглаж, олон нийтийн санаа бодлыг төдийлөн авч хэлэлцээгүй юм. Энэ нь нэр дэвшигч, сонгогч хооронд зөрчилт байдлыг бий болгосон. Нэр дэвшигч Л.Түдэвийн сонгуулийн сурталчилгааны эсрэг ойлголтууд нь тухайн цаг үед олон нийтийн сэтгэл зүйд хүчтэй нөлөө үзүүлж байв. Л.Түдэв бол “Ю.Цэдэнбал түүний “авгай” Филатовагийн ойрын хүн, тойрон хүрээлэгч”, “улс орны нэн чухал салбар, том бүтээн байгуулалт бус үзэл суртлын ажилд түлхүү оролцож явсан”, “ардчилал өөрчлөлтийн үйл явцад идэвхтэй байр суурь, оролцоо байхгүй”, “ардчилалд үл итгэх хандлагатай” зэрэг тайлбарууд ноёрхож байлаа. Энэ нь шинэ үеийн удирдагчид байх ёстой, олон нийтийн сэтгэл зүйлд таалагдах зарчимд үл нийцэв. Хувь хүний зан чанар, мэдлэг, чадварыг хэт шүтсэн нь тухайн цаг үе, нөхцөл байдлаа мэдрээгүй, дутуу үнэлсэнд оршино. Мөн “... дэвшил гаргахад дэглэм хэрэгтэй” гэсэн үг тайлбар нь “коммунизм, дарангуйллыг дахин сэргээх нь” гэсэн ойлголтыг нийгэмд төрүүлжээ. Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь социалист тогтолцооны үе мэт олон нийтэд зааж сургадаг, чиглүүлдэг бус харин тэдний хүсэл сонирхлыг дээдлэгч, хангагч байхыг шаарддаг цаг үеийн өөрчлөлтийг нэрт эрдэмтэн анзаараагүй юм. Түүнд улс төрийн лидерийн

имижийн хамгийн гол хүчин зүйл болох ирээдүй, өнөөгийн бодит байдалд тулгарч буй саад бэрхшээл, хямралыг хэрхэн даван туулах төлөвлөгөө, үзэл санаа, амлалт байсангүй. Нэр дэвшигч Л.Түдэв олон нийтийн санаа бодолд нийцэх үзэл баримтлалгүй байснаа хожим хүлээн зөвшөөрсөн байдаг.

Хэцүү цаг үед өөдрөг үзэл санаа, ирээдүйд чиглэсэн ажил хэрэгч хөтөлбөр байгаагүй нь МАХН-ын гол алдаа юм. Олон нийт тухайн цаг үеийнхээ эдийн засгийн хямрал уналтын гол шалтгаан, үндэслэлийг МАХН-аас илүүтэй үнэлж дүгнэж байсан. Иймдээ ч цоо шинэ лидер, ардчилсан хүчний улс төрчийг илүү дэмжин, тухайн нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаа ч нийгэм, сонгогчдыг итгүүлэн үнэмшүүлж байв. Харин энэ үеэр нэр дэвшигч Л.Түдэвийн мэдээлэл сурталчилгаа нь түүнийг “хагас бурхан” (архи тамхи хэрэглэдэггүй, дэлхийн утга зохиолын бүх сонгодог бүтээлийг уншсан, амьдралынхаа төлөвлөгөөг сар өдрөөр гаргадаг) мэт агуулга санааг тодотгож байлаа.

Өөрчлөлт шинэчлэлтийн үеийн улс төрчийн имиж нь энгийн хүн байх, бусадтай ижил нэгэн гэдэг зарчмыг тулгуур болгосон. Хувь хүний чадвар, онцлог, давуу тал, манлайлагч дүр төрх нь хүний эгэл ертөнц, энгийн амьдралаас “тасарч” болохгүй. 1993 оны Монголын нийгмийн оюун санаанд удирдагч, лидерийн төгс байдлын тухай зохиомол, суртал ухуулгаас залхсан, үл итгэсэн хандлага давамгайлж байсан. Хувийн өмч, чөлөөт зах зээлийг

дээдэлж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хараат бус шийдвэр гаргах боломж нээгдсэн үед дээрээс шууд захирах, зааварлах (үйлдвэрлэгч байх, дэвшилд хүрэх дэглэм хэрэгтэй) тухай үг яриа хэлсэн нь олон нийтэд таалагдахгүй нь ойлгомжтой. Нэрт соён гэгээрүүлэгч Л.Түдэв өндөр мэдлэг боловсролтой, оюун санааны хувьд гарцаагүй лидер байсан нь ирээдүйд улс төрийн бодлого чиглэл хаашаа, хэрхэн өрнөснөөр харж болно. Гэвч тухайн он цагт түүнийг эергээр дэмжих нийгэм, олон нийтийн ухамсар, туршлага байсангүй. Тэрээр нөлөө бүхий нийтлэлч, соён гэгээрүүлэгч, зохиолч, эрдэмтэн гээд тухайн үедээ хүлээн зөвшөөрөгдөх эерэг, давуу талтай байсан ч сонгуульд оролцох бодлого, зорилго сул (өөрөө дургүй байсан) нийгэм цаг үеийнхээ өөрчлөлтийг үл ойшоосон, нэгэнт бий болсон нэр хүнддээ хэт найдсан зэрэг нь амжилт олоогүй гол үндэс байжээ. Харин түүний өрсөлдөгч П.Очирбат сонгуулийн шинэ арга баримтлан иргэдтэй хийх уулзалт, ам дамжсан яриа, телевиз сонин радио ашиглан өөрийн сурталчилгааг амжилттай явуулсан юм.

**А**рдчилсан хүчнээс нэр дэвшсэн П.Очирбатын гол имиж нь ардчилалд ээлтэй, улс орны ирээдүйг уул уурхай, дэд бүтцийн салбар авч явах тухай номлол байв. Түүнд аливаа асуудалтай танилцах биш шууд шийдвэрлэх төрийн туршлага (эрчим хүч, гадаад худалдааны сайд, дарга байсан) мөн анхны Ерөнхийлөгч хэмээх албан тушаал байлаа. 1992 оны сонгуу-

лиар МАХН парламентын 76 суудлын 70-ыг авч үнэмлэхүй олонхоор эрх баригч болсон. Ерөнхийлөгч П.Очирбат 1993 он хүртэл МАХН-ын тэргүүн эгнээд явж ирсэн. Харамсалтай нь Монгол-Хятадын харилцаанд баримталж буй бодлого нь шүүмжлэлд өртөн, намаасаа шахагджээ. Нэр дэвшигч П.Очирбат нь ялагдашгүй өрсөлдөгч биш байсан бөгөөд гагцхүү өөрийн сонгуулийн өвөрмөц технологи, имиж бүрдүүлэлт, сурталчилгаагаар ялгарч чадсан юм. Тэрээр улс төрийн туршлага, мэдлэгээр ялгарч байв. Түүний сонгуулийн уриа “Гарам дээр морио сольдоггүй” гэсэн Монгол хэлц үг, нөгөө талаас ардчилал өөрчлөлтийн үйл явцыг үргэлжлүүлэх санаа, нэгэнт сонгогдсон Ерөнхийлөгчийн албан тушаалаа хадгалах гээд олон талаар энгийн ойлгомжтой тодорхой утга агуулгатай байв. Түүнчлэн ард түмэн ардчилсан хүчинд итгэл найдвар үзүүлж байсан ч сонгуулийн туршлага дутмаг, зохион байгуулалт муу, нэр дэвших хүн цөөн байсан шалтгаанаар парламентын сонгуульд ялагдсан нь нөлөөлсөн. Иргэдийн хүсэл сонирхлоор ардчилсан хүчинд улс төрийн томоохон ялалт хэрэгтэй байсан. Энэ бол нийгмийн эрэлт хэрэгцээ, цаг үеийн зайлшгүй хүлээлт байсныг тэмдэглэх хэрэгтэй. Ардчилсан тогтолцоог баталгаажуулах сонирхол, улс төрийн шинэ хүчнүүдийн парламентын сонгуульд ялагдсаны дараах ухаарал, сургамжаас үүдэлтэй нэгдэл чухал дэмжлэг үзүүлсэн. Мөн парламентад буй МАХН-ын төлөөл-

лийн 3/1 нь ерөнхийлөгч П.Очирбатад “талтай” байв. Энэ бол Монголын улс төрийн түүхэнд өрсөлдөгч хүчнээсээ томоохон, бодит дэмжлэг авч байсан эхний бөгөөд онцгой тохиолдол байжээ. Улс төрийн тодорхойгүй байдал, сонгогчдын сэтгэл зүйн савлагаа, эдийн засаг, нийгмийн уналт, хямрал гээд олон нийт бүхэлдээ айдас түгшүүрт автсан үед нүдэнд дулаахан, хээгүй, ажил амьдралын туршлагатай П.Очирбат зайлшгүй сонголт болон харагдсан. Ардчилсан үнэлэмж үнэ цэнэтэй, социализмын хүч нөлөө сулраагүй үед П.Очирбат бол нийгэм цаг үеийн захиалга, сонголт гэдэг нь ойлгомжтой юм. Мөн түүний хувь хүний мөн чанар буюу аль нэг талыг хэт баримталдаггүй, бодит нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрдөг, улс төрд зөвшилцлийг эрхэмлэдэг нь улс төрийн хошуучлагчийн гол үүрэгт бүрэн нийцсэн юм. Улс орон, ард түмний бүрэн бүтэн байдлыг хадгалах, нийгмийн бүх давхаргын эрх ашгийг нэгтгэх, эдийн засгийн хямралын эсрэг том төсөл хөдөлгөх зэрэг түүний үүрэг оролцоо их байв.

**Н**эр дэвшигч П.Очирбатын сонгуулийн сурталчилгааны гол хэрэгсэл нь сонгогчидтой хийх уулзалт, орон нутгийн томилолт, телевиз сонин хэвлэл, сурталчилгааны хуудас, радио мэдээлэл байв. Тэрээр аман харилцаа давамгайлсан сонгуулийн компанит ажлыг эрхэмлэсэн. Улс төрийн PR ажиллагаанд аман харилцаа-цуурхалыг онцгойлон авч үздэг. Улс төрчийн талаарх шинэ үзэл бодлыг ард түмний сэтгэлгээнд бий болгох,

түүнийгээ шинэ орчин нөхцөл, орон зайд түгээхийг PR-ийн цуурайтуулах үүрэг гэнэ (Г.Өнөрбаяр, 2004). PR-ийн цуурайтуулах үүрэг нь цуурхлыг бий болгодог. Үнэн худал нь тухайн үедээ батлагддаггүй, тодорхой зорилгын үүднээс түгээгдсэн, зохион байгуулагдсан, цааш түгэн дэлгэрэх боломж бүхий харилцааг цуурхал гэдэг (Г.Өнөрбаяр, 2004). Цуурхал нь өөрөө цааш түгэн дэлгэрэх боломжтой мэдээллийн сайн сүлжээ болно. Хөгжилд хүрсэн улс орнуудад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээсэн цуурхал нөлөөтэй бол манайд аман хэлбэрээр түгээсэн цуурхал илүү хүчтэй мөн амжилт олдог. 1993 онд Монголд ганцхан телевиз ажиллаж байв. 1989 онд зуугаад сонин сэтгүүл гарч байсан бол 1991 оны 7 сар гэхэд 155 сонин шинээр гарч, нүүдлийн соёл уламжлалаа хадгалж ирсэн Монгол орны сонин сэтгүүлийн тоо 1993 онд 270-аас илүү болсон (М.Мөнхмандах, 1998).

**Н**эгэнт телевизийн хүртээмж хангалтгүй байсан тул нэр дэвшигчид сонгогчидтой хийх уулзалт, телевизийн мэдээ, сонин сэтгүүл, аман мэдээлэл-цуурхалд ач холбогдол өгч байв. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хожуу бүрэлдсэн нь манай ард түмний дунд аман мэдээлэл олон зууны турш гол үүрэг гүйцэтгэхэд хүргэсэн. Тухайн цагт хэвлэл мэдээллийн хэрэгслээс илүүтэй нэр нөлөө бүхий хүн, олны танил эрхэм, нутаг орны тулхтай хөгшдийн аман мэдээлэл-цуурхалыг найдвартай хэмээн үздэг байжээ. Гэхдээ цуурхлыг хөгжүүлэхэд ОНМХ гол

үүрэг гүйцэтгэдэг нь гарцаагүй юм. Цуурхал амжилттай байх үндсэн нөхцөл нь нийгмийн сэтгэлгээний түвшин билээ. Нийтийн боловсрол, мэдлэг сул дорой байх тусам цуурхал амжилт олох шалтгаан болдог. Ерөнхийлөгч хүн социализмын хүлээсээс ангижирч иргэдтэй “биечлэн уулздаг”, “асуултад хариулдаг”, “гар барьдаг”, “гэрэл зураг авхуулдаг” болсон нь олон нийт дунд ам дамжсан яриа болж байв.

“1993 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Л.Түдэв гуайг нэр дэвшихэд би аймгийн МАХН-ын хорооны даргаар ажиллаж байлаа... Л.Түдэв гуайд улсынхаа Ерөнхийлөгчөөр сонгогдох боломж бүрэн байсан юм. Нэр дэвшүүлэхээс эхлээд бүх үйл ажиллагаанд оролцож, эцсийн дүн гартал хамтран зүтгэсний хувьд надад бас өөрийн дүгнэлт бий. Гол нь МАХН-ын сонгуулийн штаб ажиллаж чадаагүй юм. П.Очирбат гуай МАХН-ын дотор маш олон танил дотно нөхөдтэй, очсон аймаг бүртээ дэмжигчдийн хүрээгээ нам, эвсэл харгалзалгүй тэлж, их өвөрмөц менежменттэй ажилласан. Манай аймагт /Говь-Алтай/ тэр оны 3-р сард ирж 10 шахам хоног ажиллаж, хэд хэдэн сумаар орсон, сум бүрд их сайхан сэтгэгдэл үлдээсэн байсан болохоор сонгуулийн кампанит ажлын үеэр ирээгүй боловч 10 гаруй хувийн санал авсан юм. Тэгээд ч манай аймагт ардчилсан хүчнийхнээс гадна Завхан аймгийн уугуул иргэд, бэр, хүргэчүүд олон байдаг онцлогтой. П.Очирбат гуай Л.Түдэв даргатай өрсөлдөж магадгүй гэдгээ

их эртнээс тооцоолсон юм шиг санагддаг. Алтайд өмнөхөн нь их тав, тухтай зочилсон нь ч учиртай байсан юм билээ” гэж (В.Алзахгүй, 2019) дурсамж нийтлэлдээ өгүүлжээ.

Тухайн цагт хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо хэт цөөн, технологийн хөгжил ядмаг хомс, нөгөө талаас коммунист удирдагчийн хэв шинжийг өөрчлөн сонгогчидтойгоо шууд харилцах шаардлагатай байв. Хамгийн чухал нь нийгэм, улс төрийн орчин өөрчлөгдөхөд шинэ үг, нэр томъёогоор тухайн цаг үеийг тайлбарлах, олон нийтэд ойлгуулахад уран илтгэгч П.Очирбат яг таг нийцэж байлаа. Ийм цаг үед үйл явдал, үзэгдэл, өөрчлөлтийг тодорхой, энгийн ойлгомжтой дүрслэн дүгнэх нь монголчуудын нүүдлийн соёл, аман харилцааны уламжлал, бусдын үг яриаг онцгойлон үздэг сэтгэхүйтэй таарч байв. Энэ хандлага өдгөө ч хэвээр ба аман харилцаа нь мэдээлэл авах үндсэн (20-25 хувь нь бусдын яриагаар мэдээлэл авдаг) суваг хэвээр байна. Нэр дэвшигч

П.Очирбатын имиж нь ардчилалд ээлтэй, бүрэн дэмждэг гэсэн ерөнхий ойлголтод суурилахаас гадна шинэ үг хэллэг бүхий мэдээлэл, яриа, тайлбартай нь нийцэж байсан. Ардчилсан тогтолцооны давуу тал, чөлөөт зах зээлийн ирээдүй, хувийн

өмчтэй болох үнэ цэнэ, “Азийн бар улс болох” үг яриа нь шинэ цаг үе ирсний билэг тэмдэг, тодотгол болсон. Улс орон эдийн засгийн гүн хямралд орж, ард түмний сэтгэл зүй тайван бус байх үед “Монгол Улс Азийн тав дахь бар улс” болно гэсэн хэтийн хөгжил, ирээдүйн энгийн тодорхойлолт хэлж байсан нь олон нийтийн зүгээс талархал, дэмжлэг хүлээсэн гэгддэг. Эрчим хүч, хүнд үйлдвэр, гадаад худалдааны салбарыг толгойлж байсан туршлагадаа

үндэслэн эдийн засгийн шинэчлэлт, өөрчлөлтийг тодорхойлж, итгэл үнэмшил төрүүлж байв. Алт хөтөлбөр, газрын тос олборлолт, уул уурхайн салбар гадаадын хөрөнгө оруулалт г.м танил бус ирээдүй чиглэсэн үг яриа, мэдээлэл нь бодит байдалд нийцсэн. Уламжлалт социа-



**Тухайн цагт хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо хэт цөөн, технологийн хөгжил ядмаг хомс, нөгөө талаас коммунист удирдагчийн хэв шинжийг өөрчлөн сонгогчидтойгоо шууд харилцах шаардлагатай байв. Хамгийн чухал нь нийгэм, улс төрийн орчин өөрчлөгдөхөд шинэ үг, нэр томъёогоор тухайн цаг үеийг тайлбарлах, олон нийтэд ойлгуулахад уран илтгэгч П.Очирбат яг таг нийцэж байлаа. Ийм цаг үед үйл явдал, үзэгдэл, өөрчлөлтийг тодорхой, энгийн ойлгомжтой дүрслэн дүгнэх нь Монголчуудын нүүдлийн соёл, аман харилцааны уламжлал, бусдын үг яриаг онцгойлон үздэг сэтгэхүйтэй таарч байв.**



лист нийгмийн суртал ухуулга биш нийгмийн сэтгэлзүйд нийцэх шинэ-лэг хандлагыг гарган ирэв.

- Монгол Улс хөгжил дэвшлийн шинэ цаг үед ирлээ,
- Монгол Улс Азийн бар улс болно,
- Эзэн Чингис, үндэсний ухамсар, байгалийн арвин их баялаг, дэлхийн гүрнүүдтэй эн тэнцүү байр суурь бүхий тусгаар тогтносон улс гэр

гээд нийгэм цаг үеэ өөдрөг, гэгээлгээр тодорхойлж байсан нь улс төрийн лидерийн имижийн гол цөм болох олон нийтэд таалагдах, анхаарал татах үзэл санааг бүрэн агуулж байв. Ардчилсан ерөнхий-лөгчтэйгөө хамт урагшлах итгэл, сэтгэгдлийг төрүүлж, уриалан дуудаж чадсан. Тухайн цагт төрийн тэргүүнтэйгээ уулзаж, шууд асуулт тавьж хариулт авах, гар барина гэдэг нь хувь хүний хувьд онцгой үйл явдал, онцлох агшин байлаа. 1993 оны Ерөнхийлөгчийн сонгууль нь улс төрийн харилцаа, мэдээллийн орон зайг хэт албаны, номлол суртал ухуулгын хэв шинжээс хүн хоорондын чөлөөт уулзалт болон өөрчлөгдөх үйл явцын эхлэл байв. Нэр дэвшигчийн имиж бүрдүүлэлтэд анхаарах өөр нэгэн зүйл нь өрсөлдөгч талтай харьцуулагдах, ялгарах, тодотгох арга зам юм. МАХН-ын гишүүн, социализмын үеийн сайд П.Очирбат нь коммунист намын нэр дэвшигчийн эсрэг дүр бүтээх нь чухал байжээ. Ардчилалд шилжсэн Монгол Улсын анхны Ерөнхийлөгч бол иргэддээ ойр, тэдний дуу хоолой, үзэл бодлыг тээгч, ардчилсан тогтолцоог хамгаалагч байх

байр суурийг илүүтэй тодотгон мэдээлж, сурталчилж байлаа. Тэрээр өмнөх нийгмийн үеийн хүнд суртал, үзэл суртлын дарамтыг эсэргүүцэн, ЗХУ-тай хийж ирсэн худалдааны алдагдлыг зоригтой илчилсэн нь үүнийг илтгэнэ. Тэрээр ард түмнийхээ төлөө ардчилсан хүчнийхэнтэй нийлсэн гэдэг үзэл санааг чухалчилж байв. Үг яриа төдийгүй үйлдэл хандлагаар өмнөх үеийн удирдагчдаас ялгаран, захиран тушаах, зааварчлан заахад бус сонсох, хэлэлцэх, албаны бус чин сэтгэлээсээ илэн далангүй ярилцах нь шинэ үеийн улс төрчийн имижийн мөн чанар юм. Ерөнхий-лөгч П.Очирбат нь аман харилцаа ашиглан олон нийтэд нээлттэй, шууд, ил тод байх шинэчлэлийг чадварлаг хийсэн. Улмаар улс төрийн имиж нь нүдэнд дулаахан, бусдыг сонсдог, ойлгодог гэсэн шинэ өнгө төрхийг бий болгож чадсан юм.

**П**.Очирбат нь эрх баригч МАХН-ын төв хорооны гишүүнээс Ардчилсан хүчний нэр дэвшигч болоход шинэ цагийн чадварлаг удирдагч, бие даасан улс төрийн зүтгэлтэн байсан нь илүүтэй нийцсэн. Олон нийтийн санаа бодол ч түүнийг “ардчилалд ээлтэй”, “нүдэнд дулаахан”, “итгэл даахуйц” гэсэн эерэг үнэлэлт өгч байжээ. П.Очирбатын улс төрийн имиж нь коммунизмын айдас, ардчиллыг бэхжүүлэх санаа бодолд тулгуурласан. Нэр дэвшигч Л.Түдэвийг дэмжигчдийн дийлэнх нь ирээдүйдээ гутранга хандагсад байсан бол нэр дэвшигч П.Очирбатыг сонгогчид ихэнх нь өөдрөг үзэлтэн байсан.



Тиймээс ч “ардчиллыг хамгаалагч”, “шинэ үеийн улс төрчдийн түшиг тулгуур”, “эгэл гүндүүгүй Монгол хүн” гэх имижийг зорилго болгон П.Очирбатын сурталчилгаа хийгдсэн юм.

**Х**эвлэл мэдээллээр дамжин бүрдэж буй улс төрийн имижид царай төрх, нүдний харц, бие галбир, хөдөлгөөн гээд хувь хүний биометр өгөгдөл, хүчин зүйл их холбоотой. Нэр дэвшигч П.Очирбатын нүүрний ерөнхий хэв төрх нь телевизийн дэлгэц, гэрэл зурагт нийцтэй, олон нийтэд эерэг хандлага дагуулах “нүдэнд дулаан” хэмээх Монгол үнэлэмж, төсөөлөлд нийцэж байв. Хүнс бараа бүтээгдэхүүний хомсдол, мөнгөний уналт зэрэг нийгэм эдийн засгийн хямралын үед “өгөөмөр буянтай улс орны эцэг”-ийн дүр төрх үнэ цэнэтэй буув. 1993 онд олон нийтийн санаа бодол өнөөдөртөө гутарсан, маргаашдаа итгэх итгэл алдарсан, сөрөг зөрчилт хандлага давамгайлж байлаа. Тухайн үеийн социологийн судалгаагаар “нийт хүн амын 81 хувь нь ардчилал зах зээлийн нийгэм ирээдүйд сайн сайхан амьдралыг авчирна гэдэгт итгэж, 74 хувь нь коммунизм социализмаас татгалзах нь зүйтэй” (Gallup, 1998) гэж хариулжээ. Ерөнхийлөгчид нэр дэвшигч П.Очирбатын бий болгосон улс төрчийн имиж нь “хээгүй”, “ардчилалд ээлтэй”, “гүндүүгүй Монгол эр хүн” байсан бол бий болгох ёстой манлайлал нь “ардчиллыг баталгаажуулагч”, “хөгжил дэвшлийг чиглүүлэгч” анхны ардчилсан төрийн

тэргүүн, Ерөнхийлөгч болох томъёолд оршиж байлаа.

Улс төрийн имиж төлөвшил нь олон нийтийн сэтгэлзүйн гутранги эсвэл өөдрөг, дэврүүн төлөв байдалд тулгуурладаг. 1993 оны ерөнхийлөгчийн сонгуулиар хөгжилд дэвшилд уриалагч, өөрчлөлт, шинэчлэлтийг хамгаалагч нь П.Очирбат байж нийт сонгогчдын 57.78 хувийн санал авч ялсан. Нэр дэвшигч П.Очирбат аман яриа ашиглан өөртөө давуу байдал авчирсан олон тохиолдол бий. Тухайлбал түүнийг “Хятадын эрлийз” гэсэн цуу яриа ихэд тархаж, хүмүүсийн ярианы гол сэдэв болсон юм. Ерөнхийлөгч П.Очирбатыг хаа явсан газар нь хүмүүс хамгийн түрүүнд асуудаг байжээ. Соёлын төв өргөөнд залуучуудтай хийсэн уулзалтын үеэр нэгэн оюутан босож “Таныг Хятадын эрлийз гээд байх юм. Энэ үнэн үү? гэж зоримогхон асуужээ. Нэр дэвшигч П.Очирбат инээмсэглэн босоод “Ийм яриаг хүмүүс тараагаад байгаа юм. Гэхдээ үнэнийг нь хэлье. Би бол Монголын хамгийн хүйтэн цэг болсон Завхан аймгийн хүн. Манайх мөнх цаст Отгонтэнгэр хайрхны өвөрт нутагладаг байсан юм. Би өөрийнхөө төрсөн үеийг хөөгөөд бодоход яг идэр есийн хүйтэнд ээжийнхээ хэвлийд олдсон байдаг. Та нар боддоо. Идэр есийн хүйтэнд Монголын хамгийн хүйтний туйл болсон оргил газар нэг муу шаахайтай хужаа намайг хийх гээд явах юм гэнэ ээ” гэж хэлээд залуучуудыг инээлгэжээ. Дараа нь залгуулан Үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордонд настайчуудтай уулзалт хий-

жээ. Энэ үеэр өнөөх домогт асуултыг нь нэгэн эмгэн асууж тайлбарлахыг шаарджээ. Нэр дэвшигч П.Очирбат бас л инээмсэглээд “Би Социализмын үед сургууль төгсөөд төв хороонд ажилд орсон. Тэр үеийн төв хороонд ямар хүмүүсийг шалгаж ажилд авдаг байсныг та бүхэн мэднэ. Хэрвээ би Хятадын эрлийз байсан юм бол төв хороонд ажилд орох нь байтугай сургуульд ч орох эрхгүй байх байлаа. Тэр үеийн ийм шалгуурыг та бүхэн сайн мэднэ дээ” хэмээн тайлбарлаж хүмүүсийг инээлгэн алга ташуулжээ (Г.Өнөрбаяр, 2008). Ингэж л цуурхлыг нас насны онцлог, нөхцөл байдалтай нь уялдуулан хоёр өөрөөр тайлбарлан олон нийтийн дэмжлэг авч байжээ. Энэ бол Ерөнхийлөгч П.Очирбат олон нийттэй харилцах, нийгмийн сэтгэл зүйг мэдрэх онцгой чадвар, өвөрмөц арга барилтай байсныг гэрчлэх баримт юм.

**Е**рөнхийлөгчид нэр дэвшиж буй улс төрийн лидерийн имиж нь дан ганц нам бус үзэл санааны лидер байхад оршино. Лидер хүн улс орныхоо ирээдүйг харж, шинэчлэл, өөрчлөлтийг мэдрч, түүнд нийгэм, олон нийтийг дагуулах итгэл үнэмшил, дүр төсөөллийг бий болгох учиртай. Нэр дэвшигч П.Очирбат үзэл санааны лидер байсан бол нэр дэвшигч Л.Түдэв намынхаа ч лидер байсангүй. Ерөнхийлөгч П.Очирбат нь ардчиллын лидер гэхээсээ илүүтэй алсын хараатай, ирээдүйн хөгжил, дэвшилд хөтлөх үзэл санааны лидер байлаа. Коммунист намын нөлөө бүхий улс төрч ардчилсан хүчний

нэр дэвшигч болон сонгуульд ялна гэдэг үнэхээр онцгой үзэгдэл мөн. Энэ үйл явдлыг тухайн цаг үеийн нийгэм олон нийтийн өвөрмөц хандлага, нөхцөл байдал, эрэлт хэрэгцээтэй холбон тайлбарлахаас өөр аргагүй.

“Нэрт соён гэгээрүүлэгч Л.Түдэв 1993 оны ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшин, П.Очирбаттай өрсөлдөж байсан юм. Энэ цаг үед хийгдсэн социологи болон, мониторингийн судалгаа байхгүй. Иргэдийн олонх нь монголчууд яаж мунхрахаараа аугаа их соён гэгээрүүлэгч, их бичгийн хүн Лодонгийн Түдэвийг хойш тавьж, Уул уурхайн яамны хурган дарга байсан Пунсалмаагийн Очирбатыг сонгосон юм бол гэж санагдана. Тухайн цаг үед ард түмний олонх нь өөрсөдтэйгөө ижил төстэй, хэнэггүй, хээгүй, гүндүүгүй, олон нийтэд таалагдах харизмтай П.Очирбатыг дэмжсэн ...Телевизийн мэтгэлцээнд оролцоходоо ч П.Очирбат ард түмний олонход таалагдаж чадсан” (Д.Дамдинжав, 2018).

1993 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшигч Л.Түдэв эрдэмтэн, зохиолч, үлгэр жишээ сэхээтэн гэсэн имиж, дүр төрх бүтээсэн. Гэвч түүний болон МАХН нь өөрчлөлт шинэчлэлийг ойлгоогүй, цаг үе, сонгогч олон нийтээ мэдрээгүй нь улс төрийн ялагдал хүлээх гол шалтгаан болсон юм.

#### Эшлэл

1. Орч Ганбат. Д. Арэнд Лийпхарт: Ардчиллын хэв загвар. УБ. 2007. 9 дэх тал.

2. Төгөлдөр. Я. Бумдарь. Д. Ерөнхийлөгч ба түүний бүрэн эрхийн талаар сонгогчийн мэдэх ёстой зүйл. УБ. 2021. 5 дах тал.
3. Дамдинжав. Д. Сийлүү дардаг бажгар. 2018.12.15. tug.mn
4. Өнөрбаяр. Г. Улс төрийн PR. 2004. УБ. 76 дахь тал.
5. Өнөрбаяр. Г. Улс төрийн PR. 2004. УБ. 76 дахь тал.
6. Мөнхмандах. М. Монголын хэвлэл мэдээлэл 1990-ээд онд. 1998 он.
7. Алзахгүй. В. Олны дотроос онцгой хүн буюу миний мэдэх Лодонгийн Түдэв. 2019.04.23. control.mn.
8. "Gallar" төвийн судалгаа 1993 он
9. Өнөрбаяр. Г. Улс төрийн PR үүнийг яаж хийдэг вэ? УБ. 2008. 32 тал.
10. Дамдинжав. Д. Сийлүү дардаг бажгар. 2018.12.15. tug.mn
4. Ганбат Д. Арэнд Лийпхарт. Ардчиллын хэв загвар. УБ. 2007.
5. Дамдинжав. Д. Сийлүү дардаг бажгар.
6. Мөнхмандах М. Монголын хэвлэл мэдээлэл 1990-ээд онд. 1998.
7. Төгөлдөр Я. Бумдарь Д. Ерөнхийлөгч ба түүний бүрэн эрхийн талаар сонгогчийн мэдэх ёстой зүйл. УБ. 2021.
8. Өнөрбаяр Г. Улс төрийн PR. УБ. 2004.
9. Өнөрбаяр Г. Улс төрийн PR үүнийг яаж хийдэг вэ?. УБ. 2008.

### Summary

A presidential candidate is a leader of a society, not a party. A leader must see the future of his country, feel the reforms and changes, and create the beliefs and visions that will lead the society and the public. Candidate P. Ochirbat was a political leader, while candidate L. Tudev was not recognized by the party. President P. Ochirbat was more of a visionary, future leader than a democratic leader. The fact that an influential Communist politician is a candidate for the democratic forces and wins the election is a very special phenomenon. This event can only be explained by the unique attitudes, circumstances and needs of the society at that time.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Алзахгүй В. Олны дотроос онцгой хүн буюу миний мэдэх Лодонгийн Түдэв.
2. Болд-Эрдэнэ Б. Нийгмийн харилцааны онол /PR/ онол практик. УБ. 2017.
3. Болд-Эрдэнэ Б. Олон нийтийн харилцаа. УБ. 2006.